



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 01 өдөр

Дугаар A/58

Мандалговь

Г Сангхүүгийн ажилтны мэдлэг
мэргэжлийн түвшинг дээшлүүлэх талаар
авах арга хэмжээний тухай

Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 19 дугаар зүйлийн 19.6.2, 19.6.3 дэх заалт, Сангийн сайдын 2012 оны 294 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавих шаардлага, шалгуур журам”-ыг тус тус үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Бүртгэл, санхүү, эдийн засгийн тэргүүний ажилтны улсын зөвлөгөөнийг угтан сумдын санхүүгийн албаны дарга, мэргэжилтэн, Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудын нягтлан бодогч, эд хариуцагч нарын мэдлэг боловсрол, мэргэжлийн дадлага туршлагын түвшин тогтоох ажлыг хоёр дугаар улиралд багтаан зохион байгуулахыг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат)-д даалгасугай.

Хоёр. Түвшин тогтоолтын байдалд тулгуурлан нягтлан бодогч, санхүүгийн ажилтнуудын мэдлэг, дадлагыг дээшлүүлэх сургалт дадлагын ажлыг холбогдох байгууллагуутдай хамтран эхний хагас жилд багтаан явуулахыг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга дарга (А.Ганбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



488010155